



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР
**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**

Улсын Их Хурлын тамгын газрын 1 дүгээр байр,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/факс: (976-51) 26 45 36,

Цахим шуудан: prd.institute@parliament.mn,
Цахим хуудас: www.research.parliament.mn

2025.07.31 № ПГ-01/316

танай _____-ны № _____-г

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БОЛОРМАА ТАНАА

“Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд
нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн
зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгааг
гүйцэтгэн үүгээр хүргүүлж байна.

ЗАХИРАЛ  Д.БУМДАРЬ

1525000789



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД
НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Судалгааны төрөл: **Харьцуулсан судалгаа**
Судалгааны код: **СТ-25/235**
Огноо: **2025.07.28**

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн Х.Болормаа

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт
Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр

Судалгаа удирдсан: Зөвлөх Г.Билгээ

Судлаач: Г.Энхсаруул, Э.Тэмүүгээ

Улаанбаатар хот
2025

АГУУЛГА

УДИРТГАЛ	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	2
1.1. “МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ” ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ	2
1.2. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ	2
1.3. БУСАД ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ	3
ХОЁР. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ	5
ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	6
3.1. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААД УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖУУД	6
3.1.1 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС (АНУ)	7
3.1.2. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС (ОХУ)	8
3.1.3. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС (БНХАУ)	9
3.1.4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (БНСУ)	11
3.1.5. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (ХБНГУ)	13
3.1.6. ЯПОН УЛС	14
3.1.7. ТАЙЛАНДЫН ХААНТ УЛС	15
3.2. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ	15
3.2.1 ХЯНАЛТ ТАВИХ ТӨВ БАЙГУУЛЛАГА, ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭ	16
3.2.2 ТУСГАЙЛСАН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУД	17
3.3. ЗӨВШӨӨРЛИЙН ДАГУУ МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИС АШИГЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	18
3.4. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮДЭХ ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ	20
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	22
НОМ ЗҮЙ	24

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол улсын эрүүгийн хуулийн зохицуулалт	3
Хүснэгт 2. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих ажиллагааг зохицуулж буй хуулийн жагсаалт	6
Хүснэгт 3. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 228 ба 228.1 дүгээр зүйлийн хэрэгжилтийн хүрээнд мансууруулах бодисуудын жингийн ангилал (граммаар)	8
Хүснэгт 4. БНХАУ-ын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэрэгт оногдуулах ял.....	10
Хүснэгт 5. БНСУ-ын “Мансууруулах бодисын хяналтын тухай хууль”-ийн 58, 59-р зүйл.....	12
Хүснэгт 6. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих ажиллагааг зохицуулж буй төрийн захиргааны төв байгууллага.....	16
Хүснэгт 7. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын жагсаалт	17

УДИРТГАЛ

“Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн олон улсын зохицуулалтыг харьцуулан судалж, тэдгээрийн ялгаа, онцлог болон сайн туршлага болохуйц зохицуулалтыг тодруулах.

Судалгааны хамрах хүрээ: Олон улсын хэмжээнд хэрэгжиж буй хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлж буй гэрээ, конвенц, Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Тайландын Хаант Улс, Япон Улсын хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг зохицуулж буй хууль, тогтоомжийг харьцуулан судалсан болно.

Судалгааны арга зүй: Судалгаанд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан олон улсын конвенц болон судалгааны хүрээнд сонгосон гадаадын улс орны холбогдох хууль тогтоомжийг харьцуулан судлах үүднээс харьцуулсан шинжилгээний арга, хууль зүйн баримт бичгийн судалгааны арга ашигласан болно.

Судалгааны бүтэц: Энэхүү судалгаа нь удиртгал, дэлгэрэнгүй хэсэг болон судалгааны үр дүнгээс бүрдэнэ. Судалгааны дэлгэрэнгүй хэсэг нь 4 бүлгээс бүрдэх бөгөөд үүнд: Нэгдүгээр бүлэгт хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын талаар, хоёрдугаар бүлэгт олон улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээнд хязгаар тавьж буй олон улсын гэрээ, конвенцууд, гуравдугаар бүлэгт гадаадын зарим нэг орны эрх зүйн зохицуулалтын талаар, дөрөвдүгээр бүлэгт судалгааны үр дүн гэх хэсгүүдээс бүрдэнэ.

Түлхүүр үгс: хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодис, мансууруулах эм, хяналт тавих, ангилал, хор уршиг, хууль бус эргэлт, эрүүгийн болон зөрчлийн хариуцлага, хил, гаалийн хяналтын байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага

Key words: narcotic drugs, psychotropic substances, addictive medicines, control, classification, harmful consequences, illicit trafficking, criminal and administrative liability, border and customs authorities, investigative authorities

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг Улсын Их Хурлаас 2002 оны 11-р сарын 28-ны өдөр баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” бие даасан хууль болон Эрүүгийн хуулиар голчлон зохицуулж байгаа бөгөөд мансууруулах эм, бодисын зарим тодорхой эргэлттэй холбоотой асуудлыг бусад салбарын хуулиар зохицуулж байна.

1.1. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн зохицуулалт

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3-р зүйлд зааснаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар энэ хууль, бусад хуульд тогтоосон үйл ажиллагааг хэлнэ” гэж тайлбарласан.¹ Харин “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенц, “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцын жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг” хэлнэ гэж тодорхойлж өгчээ.

Үүнээс үзэхэд уг хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эргэлдэж буй бүхий л Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хянах өргөн хэрэгжилтийн цар хүрээтэй хууль юм. Харин тус хуулийн 4-р зүйлээр эмчилгээ, шинжилгээ, судалгаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэхийг зөвшөөрсөн байна.

Энэхүү хуулийн зөрчлийн хариуцлагыг эрүүгийн эсхүл зөрчлийн хуульд зааснаар хүлээлгэнэ. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хууль нь энэ төрлийн эм, бодисын хэрэглээ, эргэлтэд хяналт тавих хэрэгцээг хангах эрх зүйн чухал ач холбогдолтой хууль юм.

1.2. Эрүүгийн хуулийн зохицуулалт

Эрүүгийн хуулийн² “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг” буюу хорьдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, хэрэглэх орон байраар хангах, завших, хууль бусаар тариалах зэргийг гэмт хэрэгт тооцон ял шийтгэлийг тодорхойлж өгсөн байна.

Доорх хүснэгтээр эрүүгийн хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргүүдийн ял шийтгэлийг харуулсан болно.

¹ Монгол Улс: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай (2002). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=315>

² Монгол Улс: Эрүүгийн хууль (2015). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail/11634>

Хүснэгт 1. Монгол улсын эрүүгийн хуулийн зохицуулалт

Хуулийн зүйл	Гэмт хэрэг	Ял шийтгэл
20.7	Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан	1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах эсхүл 1-5 жил хүртэл хорих ял
	Худалдаалах зорилгоор олж авсан, бэлтгэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан	2-8 жил хүртэл хорих ял
	Энэ гэмт хэргийг байнга тогтвортой, улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн	5-12 жил хүртэл хорих ял
	Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	12-20 жил эсхүл бүх насаар хорих ял
	Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн	Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрх хасах ба 40,000-200,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох
	Гэмт хэрэг илрүүлэхэд тусалсан, сайн дураар мэдүүлсэн	Ялаас чөлөөлнө
20.8	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангасан	5,400-27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл 1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах эсхүл 1-5 жил хүртэл хорих ял
	Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	5-12 жил хүртэл хорих ял
20.9	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 2-5 жилээр хасах ба 5,400-27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл 1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах эсхүл 1-5 жил хүртэл хорих ял
20.10	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан	1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах эсхүл 1-5 жил хүртэл хорих ял
	Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	5-12 жил хүртэл хорих
	Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, ашиг сонирхлын төлөө үйлдсэн	Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрх хасах ба 40,000-200,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

1.3. Бусад хуулийн зохицуулалт

Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн³ хоёрдугаар бүлэгт мансууруулах эм үйлдвэрлэх, экспортлох, импортлох, нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрлийг эрх бүхий комиссын шийдвэрээр олгоно хэмээн заасан.

Харин Байгалийн ургамалын тухай хуулийн⁴ 20-р зүйлд “Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн

³ Монгол Улс: Эм эмнэлгийн хэрэгслийн тухай (2024). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140713569541%20>

⁴ Монгол Улс: Байгалийн ургамалын тухай (1995). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=76>

захиргааны төв байгууллага мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн олгож, зөвшөөрлийг тусгай бүртгэлд бүртгэнэ. Зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарихыг хориглоно” хэмээн заасан байна.

ХОЁР. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ

Хар тамхи болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, түгээлт, үйлдвэрлэл нь зөвхөн хувь хүний эрүүл мэндэд бус, улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдалд ноцтой заналхийлэл учруулдаг. Үүний улмаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг хязгаарлах, улс орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллага олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх гурван суурь конвенц батлан гаргасан. Эдгээр конвенцын үндсэн зорилго нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг хориглох бус харин түүний хэрэглээнд хязгаар тавих, хэрэглээг хянах, эмчилгээний болон шинжлэх ухааны зориулалтаар ашиглах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Энэхүү гурван конвенцын хамгийн анхдагч нь 1961 оны 3 дугаар сарын 25-ний өдөр батлагдсан “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”⁵ юм. Уг конвенцоор уламжлалт мансууруулах бодисууд болох опиум, кокаин, каннабис зэрэг бодисууд болон тэдгээрийн үндсэн түүхий эд болох кока бут, олс (cannabis plant), опиумын намууг тодорхойлон ангилж, тэдгээрийн үйлдвэрлэл, экспорт, импорт, хадгалалт, хэрэглээг тусгай зөвшөөрөл, бүртгэл, тайлагнах зэрэг хатуу журмаар зохицуулсан (§29, §31, §34). Конвенцод нэгдэн орсон талууд мансууруулах үйлчилгээтэй бодис, эм, бүтээгдэхүүний хэрэглээ, үйлдвэрлэл, экспорт, импорт, хадгалахыг зөвхөн анагаах ухаан болон эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтад хязгаарлах үүргийг хүлээх бөгөөд энэхүү конвенцын журмын дагуу олон улсын хэмжээн дэх мансууруулах бодисын хяналтын чиг үүргийг Мансууруулах эмд хяналт тавих олон улсын хороонд хариуцуулна.

1971 оны 2 дугаар сарын 21-нд батлагдсан “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай”⁶ конвенц нь 1961 оны конвенцод тусгагдаагүй, шинээр гарч ирсэн синтетик болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисуудын хэрэглээг зохицуулахад чиглэгдсэн (§2.04, §2.05) . Энэхүү конвенцоор амфетамин, барбитурат зэрэг сэтгэцэд нөлөөтэй бодисын үйлдвэрлэл, хэрэглээ, тархалтад хяналт тогтоосон (§5, §6, §7, §8). Ялангуяа энэ конвенц нь тухайн бодис эмнэлгийн зориулалтаар ашиглах ач холбогдолтой боловч хууль бус хэрэглээнд өртөмтгий байж болох тохиолдолд хэрхэн тэнцвэртэй зохицуулалт хийх талаарх үндсэн зарчмыг тусгасан байдгаараа онцлог.

Харин 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг”⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц нь мансууруулах бодисын хууль бус эргэлт, түүнтэй холбогдох мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн хоригийн үндсийг тавихад анхаарсан.

Дээрх гурван конвенцод Монгол улс болон судалгаанд хамрагдсан бүх улс нэгдэн орсон бөгөөд тухайн бодисын шинж чанар, хэрэглэх зориулалт, хууль бус эргэлтэд өртөх эрсдэл зэргээс хамааран ангилал тогтоож, хяналт бүртгэлийн арга хэмжээг үе шаттайгаар тогтоодог. Ингэснээр улс орнууд өөрийн хууль тогтоомжийг эдгээр олон улсын стандартад нийцүүлж, дотоодын хяналтын тогтолцоогоо улам боловсронгуй болгох шаардлагатай болдог. Түүнчлэн эдгээр конвенцууд нь эрүүл мэнд, хууль сахиулах, гааль, шүүх, прокурор зэрэг байгууллагуудын олон талт хамтын ажиллагааг уялдуулах чухал гарын авлага болж байна.

⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллага (1961). Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц [Single Convention on Narcotic Drugs]. Хандах: https://www.unodc.org/pdf/convention_1961_en.pdf

⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллага (1971). Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц [Convention on Psychotropic Substances]. Хандах: https://www.unodc.org/pdf/convention_1971_en.pdf

⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллага (1988). Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц [United Nations Convention Against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances]. Хандах: https://www.unodc.org/pdf/convention_1988_en.pdf

ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн харилцааг зохицуулж буй гадаад улсын хууль, тогтоомжууд

Судалгаанд хамрагдсан бүх улсын хувьд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд төрийн зүгээс хяналт тавих, хязгаарлах нийтлэг хандлагатай байна. Гэсэн хэдий ч тус ажиллагааны эрх зүйн зохицуулалт улс орон бүрд харилцан адилгүй. Дараах хүснэгтэд хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн орчныг зохицуулж буй судалгаанд хамрагдсан улсуудын суурь хуулиудыг нэгтгэн харуулсан болно.

Хүснэгт 2. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих ажиллагааг зохицуулж буй хуулийн жагсаалт

№	Улс	Зохицуулж буй хууль тогтоомж
1	АНУ	Хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисыг хянах тухай хууль, ⁸
		Хар тамхитай тэмцэх тухай хууль ⁹
2	ОХУ	Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль ¹⁰
		Эрүүгийн хууль (§228-234) ¹¹
3	БНХАУ	Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль ¹²
		Эрүүгийн хууль (§347–357) ¹³
4	БНСУ	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хяналтын тухай хууль, ¹⁴
5	БНГУ	Мансууруулах бодисын тухай хууль ¹⁵
6	Япон	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хяналтын тухай хууль ¹⁶
		Опиумын тухай хууль ¹⁷
		Каннабисийн эргэлтэд хяналт тавих тухай хууль ¹⁸
		Хортой болон хортой нэгдлүүдийн хяналтын хууль ¹⁹
		Эмийн болон эмнэлгийн хэрэгслийн чанар, үр нөлөө, аюулгүй байдлыг хангах тухай хууль ²⁰

⁸ АНУ: Controlled Substances Act (CSA), 1970. Хандах: <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-10355/pdf/COMPS-10355.pdf>

⁹ АНУ: Anti-Drug Abuse Acts, 1986. Хандах: <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-10504/pdf/COMPS-10504.pdf>

¹⁰ ОХУ: Федеральный закон о наркотических средствах и психотропных веществах. Хандах: Federal Law of 08.01.1998 No. 3-FZ (as amended on 25.12.2023)

¹¹ ОХУ: The criminal Code, 1996. Хандах: <https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ru/ru080en.pdf>

¹² БНХАУ: Anti-Drug Law, 2008. Хандах: http://iolaw.ccssn.cn/ywb/ywflfg/criminallaw/201512/t20151216_4637457.shtml

¹³ БНХАУ: Criminal Code, 1979. Хандах: <https://www.wamathgroup.com/wp-content/uploads/2015/03/China-Criminal-Code.pdf>

¹⁴ БНСУ: Act on the Control of Narcotics" (마약류 관리에 관한 법률). Хандах:

[법령내용 | 영문보기 | 법령보기 | 대한민국영문법령](#)

¹⁵ Герман: Betäubungsmittelgesetz (BtMG), 1981. Хандах: [BtMG - Gesetz über den Verkehr mit Betäubungsmitteln](#)

¹⁶ Япон: Narcotics and Psychotropics Control Act (麻薬及び向精神薬取締法), 1953. Хандах: [Narcotics and Psychotropics Control Act - Japanese/English - Japanese Law Translation](#)

¹⁷ Япон: Opium Law, 1953. Хандах: [Opium Control Act - Japanese/English - Japanese Law Translation](#)

¹⁸ Япон: Cannabis Control Act, 1948. Хандах: [大麻取締法 - 日本語 / 英語 - 日本法令外国語訳 DB システム](#)

¹⁹ Япон: Poisonous and Deleterious Substances Control Act, 1950. Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/download/3387/09/s25Aa003030304en13.0_h30A66.pdf

²⁰ Япон: Act on Securing Quality, Efficacy and Safety of Products Including Pharmaceuticals and Medical Devices, 1960. Хандах: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3213/en>.

		Сэргээгч бодисыг хянах тухай хууль ²¹
7	Тайланд	Мансууруулах бодисын тухай хууль ²²

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

3.1.1 Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Америкийн Нэгдсэн Улс (цаашид АНУ)-ын хувьд хар тамхи, мансууруулах бодисын эргэлт, хэрэглээнд тавих хяналтыг голчлон 1970 оны Хяналттай бодисын тухай холбооны хууль (Controlled Substances Act) болон 1986 оны Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль (Anti-Drug Abuse Act) -аар нэгтгэн зохицуулсан байдаг.

А) Хяналттай бодисын тухай хууль

Уг хуулиар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таван ангилалд хувааж, эмчилгээний хэрэгцээ болон донтолт үүсгэх эрсдэлийн зэргээр нь ялгасан байдаг. Тухайлбал:

- I ангилалд эмнэлэг эмчилгээний зориулалтгүй, донтолт үүсгэх өндөр аюултай тул хэрэглээг нь хориглосон бодисууд байна. Үүнд: марихуан, героин, ЛСД (LSD), экстази зэрэг багтана .
- II ангилалд зарим тохиолдолд эмчилгээний хэрэглээнд зөвшөөрөгдсөн өндөр хэмжээний донтолт үүсгэх, сэтгэц болон бие махбодод аюул үүсгэх бодисууд хамаарна. Үүнд: кокаин, фентанил, метадон, дексирен, аделла зэрэг эм, бодисууд.
- III ангилалд донтолт үүсгэх, сэтгэцэд нөлөөлөх эрсдэл бага эм, бэлдмэл, бодисууд хамаарах бөгөөд үүнд: стеройд, тестостерон, кетамин зэрэг орно.
- IV болон V ангилалд мансууруулах, донтолт үүсгэх эрсдэл эрс бага эс, бодис бэлдмэлүүд орно.
- II-V ангиллын бодисуудыг тухай улсын Хууль зүйн яамны харьяа Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх агентлаг (DEA)-д бүртгэлтэй эмч нар л бичиж, зохих зөвшөөрлийн дагуу хэрэглэдэг бөгөөд V ангиллын зарим бодисыг жоргүй авч болох боломжтойгоор тусгажээ.

Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх агентлаг (DEA) нь Хяналттай бодисын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллага бөгөөд эмчилгээний зорилгоор дээрх эм, бодисуудын хэрэглээний жор бичих, эм олгох, хяналт тавих бүх үйл явц тус байгууллагын системээр бүртгэгддэг байна.

Мөн тус хуулийн ангиллын дагуу мансууруулах бодисын хууль бус эргэлт буюу үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалт, их хэмжээний хадгалалтын ял шийтгэл нь бодисын төрөл, хэрэглээний хэмжээнээс хамааран 5–20 жилээс бүх насаар хорих ял, их хэмжээний мөнгөн торгууль байдаг (§841, §844).

В) Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль

1986 онд батлагдсан Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль (Anti-Drug Abuse Act) нь 1970-аад оноос АНУ-д хэрэгжүүлж эхэлсэн “Хар тамхины эсрэг дайн”-ын эрх зүйн бодлогод хамаарах хууль бөгөөд хар тамхи, мансууруулах бодистой тэмцэхэд томоохон шинэчлэл авчирсан хууль юм. Энэхүү хууль нь Хяналттай бодисын тухай хуулийн зөрчлийн ял шийтгэлийн доод хэмжээг тогтоож, хар тамхи, мансууруулах бодисын эсрэг тэмцэх төрийн төсвийн дээд хэмжээг нэмсэн хууль юм.

²¹ Япон: Stimulants Control Act, 1951. Хандах: [Stimulants Control Act - English - Japanese Law Translation](#)

²² Тайланд: Narcotic Act B.E. 2522, 1979. Хандах: [Narcotics Act 2522.pdf](#)

Тус хуулийн онцлог нь хар тамхи, мансууруулах бодисын эргэлттэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн бөгөөд энэ төрлийн бодистой холбоотой мөнгө угаах гэмт хэрэг, хууль бус мөнгийг банкны дансанд оруулах, данснаас гаргах зэрэг гэмт хэргийн эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн.

3.1.2. Оросын Холбооны Улс (ОХУ)

А) Эрүүгийн хуулийн зохицуулалт

Оросын Холбооны Улсад (цаашид ОХУ) мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх өнөөгийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын үндэс нь 1996 онд Эрүүгийн хуулиар²³ тавигдсан. Уг зохицуулалтад 2012 болон 2024 онуудад нэмэлт, өөрчлөлт орсон байна. Одоогоор хар тамхи, мансууруулах бодистой холбоотой зохицуулалтууд нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн 25-р бүлэгт (228-р зүйлээс 234-р зүйл хүртэл) “Хүний эрүүл мэнд, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” гэсэн гарчгийн дор тусгагдсан байдаг²⁴.

Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг тусгайлан Эрүүгийн хуулийн 228, 228.1, 228.2, 228.3, 228.4, 229, 229.1, 230, 231, 232, 233, 234 болон 234.1 дүгээр зүйлд заасан байна. ОХУ-д бүртгэгдэж, ял шийтгэл авсан мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн дийлэнх нь Эрүүгийн хуулийн 228 болон 228.1 дүгээр зүйлд хамаардаг²⁵. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 228 дугаар зүйлд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хадгалах, эзэмших, тээвэрлэх, үйлдвэрлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцдог бол, 228.1-р зүйлд эдгээр бодисыг хууль бусаар бэлтгэх, борлуулах, хил дамнуулан зөөх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, 3–20 жил хүртэлх хорих ял оноохоор хуульчилсан байна. Ял шийтгэлийн хэмжээг тухайн хэрэгт хамаарах мансууруулах бодисын хэмжээнээс шалтгаалан тодорхойлно (§228, §228.1, §229). Энд дурдагдаж буй хэмжээ нь хар тамхи, мансууруулах бодисын хэмжээг хэлэх бөгөөд эрүүгийн хуулийн дагуу “их хэмжээ” гэх ойлголт нь тухайн мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис эсвэл түүний төст бодисын хэмжээ нь нэг удаагийн дундаж хэрэглээний тунгаас 10 болон түүнээс дээш дахин хэтэрсэн тохиолдлыг, харин “онц их хэмжээ” гэдэг нь 50 болон түүнээс дээш дахин хэтэрсэн тохиолдлыг хэлнэ. Ингэхдээ мансууруулах бодисын нийт жинг тодорхойлохдоо цэвэр мансууруулах бодисын жинг биш, харин холимгийн нийт жинг харгалзан үздэг байна. Жишээлбэл, цагдаагийн ажилтан 1 грамм героиныг 2 грамм элсэн чихэртэй хольсон 3 грамм холимог олсон тохиолдолд 3 грамм героин хураагдсан гэж үзнэ. Доорх хүснэгтэд эрүүгийн хуулийн 228 болон 228.1 дүгээр зүйлийн дагуу ОХУ-д хуульчилсан мансууруулах бодисуудын хэрэглээний “мэдэгдэхүйц хэмжээ”, “их хэмжээ”, “онц их хэмжээ” -ний жишиг хэмжээг тусгаж өгсөн болно.

Хүснэгт 3. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 228 ба 228.1 дүгээр зүйлийн хэрэгжилтийн хүрээнд мансууруулах бодисуудын жингийн ангилал (граммаар)

Бодисын нэр	Мэдэгдэхүйц хэмжээ	Их хэмжээ	Онц их хэмжээ
Марихуана	6	100	100,000
Гашиш	2	25	10,000
Гашишийн тос	0.4	5	1000
Папавер (Papaver)	20	500	100000

23 ОХУ: Criminal Code, 1996. Хандах: <https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ru/ru080en.pdf>

24 Koçoğlu, S. (2024). A review of the Russian Federation's main legal regulations on drug abuse and their impact on prevention. Хандах: https://www.addicta.com.tr/Content/files/sayilar/21/AOP-ADDCT_20240222_nlm_new_indd.pdf

25 Ekaterina Travova. (2023). “Under Pressure? Performance Evaluation of Police Officers as an Incentive to Cheat,” Journal of Economic Behavior & Organization. Хандах: <https://doi.org/10.1016/j.jebo.2023.05.021>.

Поппи (Poppy straw)	1	5	500
Метадон	0.5	2.5	1000
Героин	0.5	2.5	500
Амфетамин	0.2	1	200
Дезоморфин	0.05	0.25	10
Кокаин	0.5	5	1500
Синтетик каннабиноид	0.05	0.25	50

Эх сурвалж: Travova, E. (2023).

Харин ял шийтгэлийн хувьд, ОХУ-ын эрүүгийн хуулийн 228-р зүйлд зааснаар:

“Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис эсхүл тэдгээрийн төст бодисыг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэх эсхүл боловсруулах үйлдлийг худалдах зорилгогүйгээр их хэмжээгээр үйлдсэн бол:

- 40,000 рубль (512.40 ам.доллар) эсхүл 3 сар хүртэлх цалин, орлогын хэмжээний торгууль, эсхүл
- Гурван жил хүртэл хугацаагаар хорих ял онооно.

Онц их хэмжээгээр үйлдсэн тохиолдолд:

- 3-10 жилийн хорих ял, мөн 500,000 рубль (6405.30 ам.доллар) хүртэл эсхүл 3-10 жилийн хорих ял болон 3 жилийн хөдөлмөрийн хөлстэй тэнцэх хэмжээний торгууль онооно.

Харин мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис эсхүл тэдгээрийн төст бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах эсхүл илгээсэн тохиолдолд 228.1-р зүйлийн дагуу:

- 4–8 жилийн хугацаагаар хорих ял оногдуулна.

В) Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль

Оросын Холбооны Улсад мансууруулах бодисыг эмчилгээний зорилгоор хэрэглэх тохиолдолд эл харилцааг “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын тухай”²⁶ хуулиар зохицуулдаг бөгөөд эмч нар зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий жороор эдгээр эмийг бичиж, эмийн сангууд зохих журмын дагуу бүртгэл хөтлөн олгодог. Эмийн жор бичихэд тусгай загвар, маягт ашиглах шаардлагатай бөгөөд төрийн зүгээс жороор олгосон эмийн хэрэглээ, үлдэгдэл тоо ширхэг, хадгалалтын байдал зэргийг тогтмол хянаж, шалгалт явуулдаг.

3.1.3. Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид БНХАУ)-ын хувьд өнөөгийн байдлаар хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, эргэлтэд хяналт тавих харилцааг БНХАУ-ын эрүүгийн хууль, 2008 онд батлан гаргасан Мансууруулах бодистой тэмцэх тухай хуулиудаар голчлон зохицуулж байна.²⁷

А) Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль

БНХАУ нь 2008 онд Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль (МБТТХ)-ийг батлан гаргасан бөгөөд уг хуулиар хар тамхи, мансууруулах бодисын түүхий эдийг тарих, үйлдвэрлэх үйл ажиллагааг хянах, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдэд донтолтын эсрэг

²⁶ ОХУ: Federal Act on Narcotic Drugs and Psychotropic Substances, 1998. Хандах: [Federal Law of 08.01.1998 No. 3-FZ \(as amended on 25.12.2023\)](#)

²⁷ Embassy of the People's Republic of China in the United States. (2023, July 6). Хандах: http://us.china-embassy.gov.cn/eng/zqgs/202307/t20230706_11108971.html

тодорхойлох зэрэг зохицуулалт хийгдсэн. Харин хар тамхитай холбоотой гэмт хэргийн төрлүүд болон ял шийтгэлийг БНХАУ-ын Эрүүгийн хуульд тусгайлан заасан байдаг.

МБТТХ-ийн 2-р зүйлээр мансууруулах бодист опиум, героин, метиланилин, морфин, марихуана, кокаин болон бусад донтуулах шинж чанартай, төрийн зохицуулалтын дагуу хяналтад байгаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисуудыг хамааруулсан. Энэхүү мансууруулах бодисуудыг эрдэм шинжилгээ, эмчилгээний зориулалтад ашиглахыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд үүний тулд БНХАУ-ын Үндэсний эмийн бүтээгдэхүүний захиргаанд хандан тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байна.

Харин 59-р зүйлд зааснаар зөвшөөрөлгүйгээр

- Мансууруулах бодисыг хууль бусаар хил давуулах, худалдах, тээвэрлэх эсвэл үйлдвэрлэх;
- Мансууруулах бодисыг хууль бусаар эзэмших;
- Мансууруулах бодисыг хууль бусаар тариалах;
- Мансууруулах бодисын эх ургамлын үр эсвэл суулгацыг хууль бусаар худалдаалах, тээвэрлэх, авч явах эсвэл эзэмших;
- Мансууруулах эсвэл сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх арга, эсхүл тэдгээрийг гаргаж авахад хэрэглэх химийн бодисын тухай аргыг хууль бусаар заах;
- Бусдыг мансууруулах бодис хэрэглэх, тариулахыг албадах, өдөөх, эсвэл уруу татах, мансууруулах бодис өгөх зэрэг үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдож байвал хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ; хэрэв тухайн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдох хэмжээнд ноцтой биш бол хуульд заасан дагуу захиргааны шийтгэл оногдуулна хэмээн заажээ.

В) Эрүүгийн хууль

Эрүүгийн хууль нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг онцгой хатуу зохицуулдаг бөгөөд 347–357-р зүйлүүдэд уг төрлийн гэмт хэргийг нарийвчлан заасан байдаг. Уг заалтуудаар хар тамхи, мансууруулах бодисыг үйлдвэрлэх, тээвэрлэх, хууль бусаар хадгалах, борлуулах, импортлох, хилийн чанадад дамжуулах, бусдыг хэрэглүүлэх, мансуурлын үүр байрлуулах зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцдог. Хүснэгт 3-т мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээг тоймлов.

Хүснэгт 4. БНХАУ-ын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэрэгт оногдуулах ял

Ялын зүйлчлэл	Хуулийн зүйл заалт	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ангилал
Хамгийн хүнд (цааз, насан турш хорих)	347-р зүйл	Худалдаа, үйлдвэрлэл, тээвэрлэлтийн гэмт хэрэг
Хүнд (≥7 жилээс насан турш)	348-р зүйл	Хувийн хэрэглээ / хадгалалт
Дунд зэрэг (≤10 жил)	350-р зүйл	Прекурсор бодистой холбоотой ²⁸
Дунд зэрэг (≤10 жил)	349-р зүйл	Хамтран оролцсон / нуух

²⁸ Хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэхэд ашиглагддаг үндсэн түүхий эд, химийн бодис.

Дунд зэрэг (≤10 жил)	353-р зүйл	Хэрэглээ өдөөсөн / албадаж хэрэглүүлсэн
Дунд зэрэг (≤10 жил)	355-р зүйл	Эрүүл мэндийн салбарын зөрчил
Хөнгөн ба хүнд (≤5 эсвэл ≥5 жил)	351-р зүйл	Ургамал тарихтай холбоотой
Хөнгөн (≤3 жил)	354-р зүйл	Хэрэглэх нөхцөл бүрдүүлсэн
Хөнгөн (≤3 жил)	352-р зүйл	Үр, суулгацын эргэлт
Хувьсах (давтан гэмт хэрэгт хүндэрнэ)	356-р зүйл	Давтан гэмт хэрэг

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

БНХАУ нь “zero-tolerance” буюу мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг үл тэвчих хатуу бодлоготой бөгөөд аливаа зөрчил, гэмт хэргийг нийгмийн эсрэг ноцтой аюул гэж үзэн, шийтгэл оноохдоо өршөөл үзүүлэхгүй байх бодлого баримталдаг. Энэ бодлого нь зөвхөн Хятадын иргэдэд бус, гадаадын иргэдэд ижилхэн үйлчилдэг бөгөөд гадаадын иргэн ч гэм буруутай нь тогтоогдсон нөхцөлд дотоодын иргэдийн адил эрүүгийн хариуцлага хүлээдэг.

3.1.4. Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид БНСУ) нь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус хэрэглээ, эргэлтэд өндөр ял шийтгэл оноодог бөгөөд тус улсын хуулийн дагуу БНСУ-ын нутаг дэвсгэр дээр солонгос болон гадаад иргэд ямар ч төрлийн мансууруулах бодис хэрэглэхийг хориглодог. Түүнчлэн гадаад улсад зорчиж буй солонгос улсын иргэд энэхүү төрлийн бодисыг хэрэглэхийг хатуу хориглосон байна.²⁹

БНСУ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих харилцааг тус улсын “Мансууруулах бодисын хяналтын тухай хууль”-аар голчлон зохицуулдаг. Уг хуулийн 2-р зүйлээр мансууруулах бодисыг мансууруулах эм (narcotic drugs), сэтгэцэд нөлөөт бодис (psychotropic substances), каннабис гэсэн 3 ангилалд хуваан ялгасан байна.

“Мансууруулах эм” гэх ойлголтод дараах бодисууд орно:

- Поппи;
- Опиум;
- Кока навч;
- Поппи, опиум эсвэл кока навчнаас гарган авсан бүх төрлийн алкалоид болон түүнтэй ижил химийн найрлагатай нэгдлүүд (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно);
- Дээрх дурдсан бодисуудад хамаарахгүй боловч ижил түвшний донтуулах үйлчилгээтэй эсвэл хортой нөлөө үзүүлэхүйц химийн нэгдлүүд (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно);
- Дээрх дурдсан бодисуудыг хольсон, найруулсан бодисууд.

Сэтгэцэд нөлөөт бодис нь хүний төв мэдрэлийн тогтолцоонд нөлөөлөх чадвартай, зохисгүй хэрэглээ буюу хэт хэрэглэх үед хүний биед ноцтой хохирол эсвэл аюул учруулах бодис хэмээн тодорхойлогдсон бөгөөд үүнд:

²⁹ БНСУ: Narcotics control act (2016). Хандах:

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=37716&lang=ENG

- Маш өндөр донтуулах үйлчилгээтэй, эмчилгээний зориулалтаар хэрэглэхийг хориглосон, хэрэглэх үед хүний биед ноцтой бие махбодын эсвэл сэтгэл зүйн хамаарал үүсгэх аюултай бодис;
- Өндөр донтолт үүсгэх магадлалтай, маш хязгаарлагдмал эмчилгээний хэрэглээтэй, буруу хэрэглээ нь ноцтой бие махбодын эсвэл сэтгэл зүйн аюул үүсгэх бодис;
- Дээр дурдсан бодисуудаас харьцангуй бага донтуулах нөлөөтэй, эмчилгээний зориулалтаар хэрэглэгддэг, боловч буруу хэрэглээ нь хөнгөн бие махбодын эсвэл ноцтой сэтгэл зүйн аюултай нөлөөлөл үүсгэх бодис;
- Дээрх дурдсан бодисуудыг хольсон, найруулсан бодисууд.

Харин “каннабис” гэдэг нь олсны ургамал, түүнээс гаргаж авсан давирхай, мөн тэдгээрийг түүхий эд болгон ашиглаж үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүн, түүнчлэн ийм бодис агуулсан холимог эсвэл найрлагыг хэлнэ.

Дээрх 3 ангиллын бодисуудын хууль бус хэрэглээ, импорт, экспорт, үйлдвэрлэл зэрэгт “Мансууруулах бодисын хяналтын тухай хууль”-ийн дагуу дараах ял шийтгэлийг онооно:

Хүснэгт 5. БНСУ-ын “Мансууруулах бодисын хяналтын тухай хууль”-ийн 58, 59-р зүйл

Холбогдох зүйл	Нарийвчилсан агуулга	Шийтгэл
58-р зүйл	(1) Мансууруулах бодис импортлох/экспортлох, эсвэл импорт/экспортын зорилгоор хадгалах/тээвэрлэх (жишээ: героин, кокаин гэх мэт)	5-аас дээш жилийн хорих ял
	(2) Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис үйлдвэрлэх зорилгоор түүхий эд импортлох/экспортлох, эсвэл ийм зорилгоор хадгалах/тээвэрлэх	
	(3) Сэтгэцэд нөлөөлөх бодис буюу ийм бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлох/экспортлох, эсвэл ийм зорилгоор хадгалах/тээвэрлэх (жишээ: JWH-18, меткатинон гэх мэт)	
	(4) Сэтгэцэд нөлөөлөх бодисын түүхий эд болох ургамлаас найрлага гарган авах, эсвэл ийм ургамлыг импортлох/экспортлох, хадгалах/тээвэрлэх	
	(5) Каннабис импортлох/экспортлох, эсвэл ийм зорилгоор хадгалах/тээвэрлэх	
	(6) Сэтгэцэд нөлөөлөх бодис буюу ийм бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлох/экспортлох, эсвэл ийм зорилгоор хадгалах/тээвэрлэх (жишээ бодис: метамфетамин гэх мэт)	
	Ашиг олох зорилгоор эсхүл давтан (1)-т заасан үйлдлийг хийсэн	Цаазын ял; 10 жилээс дээш хорих ял
59-р зүйл	(1) Мансууруулах бодисын түүхий эд болох ургамлыг ургуулах, эсвэл ийм ургамлын үр, үрсэлгээ, эд ангиудыг импортлох/экспортлох зорилгоор хадгалах/тээвэрлэх	1-ээс дээш жилийн хорих ял

	(2) Сэтгэцэд нөлөөлөх бодис буюу ийм бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлох/экспортлох, хадгалах/тээвэрлэх (жишээ нь: LSZ, флунизепам гэх мэт)	
	(3) Каннабис ургамлыг экспортлох зорилгоор ургуулах	
	(4) Сэтгэцэд нөлөөлөх бодис импортлох/экспортлох	
	(1)-д заасан үйлдлийг давтан үйлдэх	

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

3.1.5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын (цаашид ХБНГУ) мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаарх эрх зүйн орчин нь харьцангуй боловсронгуй, нарийн зохицуулалттай байдаг. Тус улсын эрх зүйн тогтолцоо нь олон улсын конвенц, Европын холбооны журмуудтай нийцсэн бөгөөд бөгөөд зарим ноцтой зөрчил (мансууруулах бодисыг худалдаалах зорилгоор их хэмжээгээр хадгалах, насанд хүрээгүй хүүхдэд хар тамхи өгөх, эдгээрийг бүлэглэж үйлдэх г.м.)-д хатуу ял оноох эрх зүйн орчинтой ч, гэмт хэргийн шинж чанар харьцангуй хөнгөн тохиолдолд эмчилгээ, нөхөн сэргээлтэд чиглэсэн арга хэмжээг дэмжих бодлоготой юм.³⁰

ХБНГУ-д мансууруулах бодисын хэрэглээ, эргэлтийн талаар харилцааг 1981 оны “Мансууруулах бодисын тухай хууль” (Betäubungsmittelgesetz)³¹ -аар зохицуулдаг бөгөөд энэхүү хуулийн дагуу “Мансууруулах бодис” ойлголтод тус хуулийн 1-ээс 3-р хавсралтад жагсаасан бодис, бэлдмэлүүдийг хэлнэ. Үүнд: Гашиш, марихуан, героин, кокаин, ЛСД, амфетамин, опиум болон морфин зэрэг багтана. Харин 1-ээс 3-р хавсралтад дурдагдаагүй бодис, бэлдмэлийн хэрэглээ нь тус хуулийн зөрчилд тооцогдохгүй байна.

Мөн тус хуулийн 29-р зүйлд зааснаар дээрх дурдсан мансууруулах бодисын худалдаа, үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдан авалт, хадгалалт нь гэмт хэрэгт тооцогдох бөгөөд эрүүгийн ял шийтгэл хүлээх үндэслэл болдог.

Гэмт хэргийн ял шийтгэлийн хэмжээг мөн “Мансууруулах бодисын тухай хууль” -аар зохицуулж өгсөн бөгөөд тус хуулиар зөрчлийн хүнд ноцтой байдлын түвшнээс хамааран ял шийтгэлийн хэмжээг тогтоож өгсөн байна.

Тухайлбал, 29-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар: Мансууруулах бодисыг тарих, үйлдвэрлэх, наймаалах, импортлох, экспортлох, түгээх, өөр хэлбэрээр эргэлтэд оруулах, худалдан авах, эсвэл өөр ямар нэгэн аргаар олж авах нь бол (худалдаа, нийлүүлэлт хийсэн эсэхээс үл хамааран) тав хүртэлх жилийн хорих ял, эсвэл мөнгөн торгуулийн шийтгэлтэй хэмээн заасан.

Харин 29-р зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар: Хэрэв тус гэмт хэргийг худалдаалах, наймаалах зорилгоор үйлдсэн эсхүл бусдын эрүүл мэндэд аюул учруулсан бол нэг жилээс доошгүй хугацаагаар хорих ял оноохоор заасан.

30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар: Мансууруулах бодисыг бүлгийн зохион байгуулалттайгаар тарьсан, үйлдвэрлэсэн, наймаалсан, эсхүл 21-ээс дээш насны хүн 18-аас доош насны хүнд худалдааны зорилгоор мансууруулах бодис нийлүүлсэн,

³⁰ Ч.Нямсүрэн. (2022). Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, Хандах: https://www.uifh.mn/upload/sudalqaa/files/208_7447220.pdf

³¹ ХБНГУ: Мансууруулах бодисын тухай хууль (1981). Хандах https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/

эсвэл бусдад мансууруулах бодис нийлүүлснээс болж тэдний амь насанд аюул учруулсан, эсвэл их хэмжээгээр хууль бусаар импортолсон бол хоёр жилээс доошгүй хугацаагаар хорих ял онооно.

30а зүйлийн 1 дэх хэсэгт: Мансууруулах бодисыг их хэмжээгээр бүлгийн зохион байгуулалттайгаар тарьсан, үйлдвэрлэсэн, наймаалсан, импортолсон, экспортолсон бол тав жилээс доошгүй хугацаагаар хорих ял онооно. Мөн 21-ээс дээш насны хүн 18-аас доош насны хүнийг мансууруулах бодистой холбоотой наймаанд оролцуулсан, эсвэл мансууруулах бодисоор наймаа хийх үедээ галт зэвсэг, эсвэл хүний биед гэмтэл учруулж болох ямар нэгэн зэвсэг авч явсан бол мөн тав жилээс доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ хэмээн тус тус заасан.

3.1.6. Япон Улс

Япон улсын хувьд хар тамхи, мансууруулах бодисын эргэлт, хэрэглээг хянах харилцааг зургаан гол хуулиар зохицуулдаг. Үүнд: Каннабисийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Хортой болон хортой нэгдлүүдийн хяналтын хууль, Өдөөгч бодисын хяналтын тухай хууль, Мансуурах бодис болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хяналтын хууль, Опиумын тухай хууль, Эмийн болон эмнэлгийн хэрэгслийн чанар, үр нөлөө, аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд багтана.

- 1) Каннабисийн эргэлтэд хяналт тавих тухай хууль³² нь 1948 онд батлагдсан бөгөөд уг хуулиар каннабисийг хууль бусаар хадгалах, хэрэглэх гэмт хэргийг 5 хүртэлх жилийн хорих ялаар шийтгэнэ гэж заасан.
- 2) Хортой болон хортой нэгдлүүдийн хяналтын хуульд³³ зааснаар будаг шингэлэгч гэх мэт органик уусгагчийг хэрэглэх, хадгалах нь нэг жил хүртэл хорих, эсхүл 500,000 ¥ хүртэл торгуулиар шийтгэдэг.
- 3) Сэргээгч бодисын хяналтын тухай хууль³⁴ нь Метамфетамин зэрэг амфетамин төрлийн сэргээгч бодисыг эзэмших, хэрэглэх гэмт хэрэгт 10 жил хүртэл хорих ял шийтгэнэ хэмээн хуульчилж өгсөн.
- 4) Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хяналтын тухай хууль³⁵ (1953 он) нь Героин хадгалах, хэрэглэх гэмт хэргийг 10 жил хүртэл хорих ялаар шийтгэдэг. Бусад хар тамхи, мансууруулах бодис (кокаин, MDMA, шидэт мөөг гэх мэт) -г долоон жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэдэг.
- 5) Опиумын тухай хууль³⁶ (1954 он) нь опиумын хууль бус хадгалалт, хэрэглээг зохицуулсан хууль бөгөөд тус бодисыг хадгалсан, хэрэглэсэн тохиолдолд долоо хүртэл жилийн хорих ялын шийтгэл оноохоор хуульчилсан.
- 6) Эмийн болон эмнэлгийн хэрэгслийн чанар, үр нөлөө, аюулгүй байдлыг хангах тухай хууль³⁷ нь синтетик мансууруулах бодисыг эзэмших, хэрэглэхэд гурав хүртэлх жилийн хорих ял эсвэл 3,000,000 иен (20,332.70 ам.доллар) хүртэл торгууль оноодог.

³² Япон улс: Каннабисийн эргэлтэд хяналт тавих тухай хууль (1948). Хандах:

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2594/en>

³³ Япон улс: Хортой болон хортой нэгдлүүдийн хяналтын хуульд (1950). Хандах:

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3387/en>

³⁴ Япон улс: Сэргээгч бодисын хяналтын тухай хууль (1951). Хандах:

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2814/en>

³⁵ Япон улс: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хяналтын тухай хууль (1953). Хандах:

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2849/en>

³⁶ Япон улс: Опиумын тухай хууль (1954). Хандах:

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2849/en>

³⁷ Япон улс: Эмийн болон эмнэлгийн хэрэгслийн чанар, үр нөлөө, аюулгүй байдлыг хангах тухай хууль (1953). Хандах: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3213/en>

3.1.7. Тайландын Хаант Улс

Тайландын Хаант Улс (цаашид Тайланд улс)-д хар тамхи, мансууруулах бодисын эргэлт, хэрэглээнд тавих хяналтыг “Мансууруулах бодисын тухай хууль” (Narcotics code)³⁸-аар зохицуулдаг бөгөөд уг хуулиар мансууруулах бодисыг 5 төрлөөр ангилан зохицуулсан байна. Үүнд:

- 1) I ангилалд героин зэрэг онц аюултай бодисууд;
- 2) II ангилалд морфин, кокаин, кодеин, эмчилгээний зориулалттай опиум зэрэг энгийн түвшний мансууруулах бодисууд;
- 3) III ангилалд эмийн найрлагатай мансууруулах бодисууд хамаарах бөгөөд Эрүүл мэндийн яам (Minister of Public Health)-ны гаргасан журмын дагуу хэрэглэх боломжит бодисууд;
- 4) IV ангилалд ацетик, ангидрид зэрэг 1 ба 2-р ангиллын бодис үйлдвэрлэхэд ашигладаг химийн бодисууд;
- 5) V ангилалд 1–4-р ангилалд багтаагүй мансууруулах бодисууд.

Энэхүү ангилалд тулгуурлан мансууруулах бодисын төрлөөс хамааран ял шийтгэлийн хэмжээ ялгаатай байна. Тухайлбал, “Мансууруулах бодисын тухай хууль”-д зааснаар:

I ангиллын мансууруулах бодисыг:

- Үйлдвэрлэх, импортлох эсвэл экспортлох : Бүх насаар хорих ял болон 1,000,000–5,000,000 бат (30,955–154775 ам.доллар)-ын торгууль оногдуулна.
- Бусдад дамжуулах, худалдах, түгээх зорилгоор хадгалсан тохиолдолд: Бүх насаар хорих ял, 100,000–5,000,000 бат (3,095.50–154775 ам.доллар)-ын торгууль, эсвэл цаазын ял оноох боломжтой (яг ямар ял оноох нь олдсон бодисын хэмжээтэй шууд хамааралтай)
- Зөвхөн хадгалсан тохиолдолд: 10 жил хүртэл хорих ял эсвэл 20,000–200,000 бат (619–6,191 ам.доллар)-ын торгууль.
- Хэрэглэсэн тохиолдолд: 3 жил хүртэл хорих ял, эсвэл 10,000–60,000 бат (309.55–1,857 ам.доллар)-ын торгууль онооно.

II ангиллын мансууруулах бодисыг:

- Үйлдвэрлэх, импортлох, экспортлох: 10 жил хүртэлх хорих ял болон 100,000–1,000,000 бат (3,095.50–30,955 ам.доллар)-ын торгууль;
- Тараах буюу тараах зорилгоор хадгалсан тохиолдолд: 10 жил хүртэл хорих ял болон 20,000–200,000 бат (619–6,191 ам.доллар)-ын торгууль;
- Зөвхөн хадгалсан тохиолдолд: 5 жил хүртэл хорих, эсхүл 100,000 бат (3,095.50 ам.доллар) хүртэл торгууль
- Хэрэглэсэн тохиолдолд: 6 сараас 3 жил хүртэл хорих ял, эсхүл 10,000–60,000 бат (309.55–1,857 ам.доллар)-ын торгууль онооно зэрэг байдлаар хуульчилсан байна.

3.2. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих эрх бүхий байгууллага, түүний эрх хэмжээ

Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль ёсны болон хууль бус эргэлтэд хяналт тавих чиг үүргийг улс орон бүрд тусгай эрх бүхий байгууллагууд хэрэгжүүлдэг

³⁸ Тайланд: Narcotics Code (2021). Хандах: <https://aseannarco.oncb.go.th/uploads/Ebook/pdf/1828893714663711.pdf>

бөгөөд тэдгээр нь үндэсний хууль, олон улсын гэрээ, аюулгүй байдлын шаардлагаас хамааран өөр өөр бүтэц, зохион байгуулалттай байдаг.

3.2.1 Хяналт тавих төв байгууллага, эрхлэх асуудлын хүрээ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллага нь улс орон бүрд харилцан адилгүй бөгөөд тухайн орны эрх зүйн тогтолцооноос хамааран тухайн асуудлыг өөр мөн харилцан адилгүй чиг үүрэг бүхий яам, төрийн байгууллагуудад харьяалуулсан байна. Дараах хүснэгтээр улс орнуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээг харьцуулан харуулав.

Хүснэгт 6. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих ажиллагааг зохицуулж буй төрийн захиргааны төв байгууллага.

№	Улс	Нэр	Эрхлэх асуудлын хүрээ
1	АНУ	Хууль зүйн яам ³⁹	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2	ОХУ	Дотоод хэргийн яам ⁴⁰	Дотоод хэргийн асуудал эрхэлсэн байгууллага
3	БНХАУ	Нийгмийн аюулгүй байдлын яам ⁴¹	Олон нийтийн аюулгүй байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4	БНСУ	Хүнс, эмийн аюулгүй байдлын яам ⁴²	Хүнс, эм зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	ХБНГУ	Эрүүл мэндийн яам ⁴³	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6	Япон Улс	Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ⁴⁴	Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7	Тайланд улс	Дотоод хэргийн яам ⁴⁵	Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

³⁹ АНУ: U.S Department of Justice. Хандах: [Department of Justice | About DOJ | United States Department of Justice](#)

⁴⁰ ОХУ: Министерство внутренних дел Российской Федерации (Ministry of Internal Affairs). Хандах: [Ministry of Internal Affairs of the Russian Federation - The Russian Government](#)

⁴¹ БНХАУ: 公安部 (Ministry of Public Security). Хандах: https://english.www.gov.cn/state_council/2014/09/09/content_281474986284154.htm

⁴² БНСУ: 식품의약품안전처 (Ministry of Food and Drug Safety). Хандах: [Welcome to the Ministry of Food and Drug Safety | Ministry of Food and Drug Safety](#)

⁴³ ХБНГУ: Bundesministerium für Gesundheit, BMG (Federal Ministry of Health). Хандах: <https://www.bundesgesundheitsministerium.de/en/index.html>

⁴⁴ Япон Улс: 厚生労働省 (Ministry of Health, Labour and Welfare). Хандах: [Ministry of Health, Labour and Welfare: Pharmaceuticals and Medical Devices](#)

⁴⁵ Тайланд Улс: กระทรวงมหาดไทย (Ministry of Interior). Хандах: [กระทรวงมหาดไทย - Ministry of Interior](#)

3.2.2 Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд

Өмнөх хэсэгт дурдсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэд болон хамтран ажилладаг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тусгайлсан чиг үүрэг бүхий нэгж, агентлагууд байдаг. Дараах хүснэгтээр улс орнуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тусгай чиг үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн үйл ажиллагааны хүрээг харьцуулав.

Хүснэгт 7. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын жагсаалт

№	Улс	Тусгай байгууллагууд	Чиг үүрэг
1	АНУ	Drug Enforcement Administration (DEA)	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах
		Food and Drug Administration (FDA)	Зөвшөөрлийн дагуу ашиглаж буй мансууруулах эмийн хэрэглээнд хяналт тавих
		National Institute on Drug Abuse (NIDA)	Шинэ төрлийн мансууруулах эм, бодисын талаар судалгаа хийх
		Homeland Security Investigation (HSI)	Хил, гаалийн шалгалт явуулах
2	ОХУ	Дотоод хэргийн яам (МВД)	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах
		Тагнуулын алба (ФТС – Гаалийн алба)	Хил, гаалийн шалгалт
		Эрүүл мэндийн яам (Минздрав)	Хяналттай бодисын жагсаалт боловсруулж, батлах, хяналт тавих, зөвшөөрөл олгох
		Холбооны Аюулгүй байдлын алба (ФСБ)	Үндэсний аюулгүй байдалд холбогдох хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах,
3	БНХАУ	Нийгмийн аюулгүй байдлын яам	Мөрдөн шалгах ажиллагаа
		Эрүүл мэндийн яам (National Health Commission, 国家卫生健康委员会)	Эмийн зохистой хэрэглээ, эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээнд хяналт тавих, хяналттай бодисын жагсаалт боловсруулах
		Хар тамхитай тэмцэх үндэсний комисс /National Narcotics Control Commission/	Үндэсний түвшинд сурталчилгаа, судалгаа зохион байгуулах, олон улсын хамтын ажиллагаа
		Гаалийн ерөнхий газар (General Administration of Customs, 海关总署)	Хилээр хууль бус мансууруулах бодис тээвэрлэхтэй тэмцэх, илрүүлэх, хураах
4	БНСУ	Үндэсний цагдаагийн агентлаг (Korean National Police Agency – KNPA)	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах
		Гаалийн ерөнхий газар (Korea Customs Service)	Хил, гаалийн хяналт
		Эрүүл мэнд, халамжийн яам (Ministry of Health and Welfare)	Зөвшөөрөлтэй бодисын эргэлтэд хяналт тавих
		Солонгосын мансууруулах бодистой тэмцэх агентлаг (Korean Narcotics Policy Division)	Үндэсний хэмжээнд бодлого боловсруулах, статистик, тайлан боловсруулах, сургалт зохион байгуулах, олон нийтэд мэдээлэл түгээх
5	ХБНГУ	Холбооны Эрүүл мэндийн яам (Bundesministerium für Gesundheit – BMG)	Хяналттай бодисын жагсаалт гаргах
		Холбооны Эрүүл мэндийн боловсролын төв (BZgA)	Мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, боловсрол, залуучууд олон нийтэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх

		Холбооны Мансууралтай тэмцэх агентлаг (Federal Drug Commissioner – Drogenbeauftragte)	Парламент, засгийн газарт судалгаа, зөвлөмж боловсруулж өгөх
		Холбооны Эрүүгийн Цагдаагийн газар (Bundeskriminalamt – BKA)	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах, олон улсын хамтын ажиллагаанд оролцох
		Холбооны Гаалийн алба (Zoll) – Гаалийн Эрүүгийн Мөрдөн Байцаах Алба	Хил, гаалийн хяналт
6	Япон Улс	Цагдаагийн газар (National Police Agency – NPA)	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах
		Гаалийн алба (Japan Customs)	Хил, гаалийн хяналт
		Япон улсын эмийн агентлаг (Pharmaceuticals and Medical Devices Agency – PMDA)	Эмийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, судалгаа, тайлан боловсруулалт
7	Тайланд Улс	Probation Department Office of the Narcotics Control Board (ONCB)	Үндэсний бодлого боловсруулах, хяналттай бодисын жагсаалт гаргах, судалгаа, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх
		Цагдаагийн ерөнхий газар (Royal Thai Police)	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах
		Эрүүл мэндийн яам (Ministry of Public Health)	Эмчилгээний хэрэглээг хянах, эмнэлгийн зөвшөөрөл олгох, нөхөн сэргээх эмчилгээ явуулах
		Гаалийн газар (Thai Customs Department)	Хил, гаалийн хяналт

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

3.3. Зөвшөөрлийн дагуу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглах эрх зүйн зохицуулалт

НҮБ-ын 1961, 1971 оны конвенцуудад тус тус заасны дагуу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн анагаах ухаан буюу эмчилгээний зорилгоор мөн эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглахыг зөвшөөрч, бусад бүх төрлийн хэрэглээг хориглодог. Судалгаанд ашиглах бодисын хэмжээг урьдчилан баталсан төсөв, хөтөлбөрөөр тогтоож, зохих байгууллагаар зөвшөөрөл авсан байх шаардлагатай байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан удирдамжид⁴⁶ мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн шинжлэх ухааны судалгаанд ашиглах тохиолдолд, тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллагад хамаарах, хууль ёсны бүртгэлтэй байхаас гадна хяналтын тогтолцоотой байх шаардлагатай.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг эмчилгээний зорилгоор хэрэглэх асуудал нь улс орнуудад нарийвчилсан, төвөгтэй байж болохуйц зохицуулалттай бөгөөд тухайн улсын эрх зүйн тогтолцоо, эм зүйн бодлого, нийгмийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарна. Эдгээр бодисыг зөв зохистойгоор хэрэглэх нь өвчтөний амь насыг аврах, зовуурь шаналгааг нь намдаах гэх мэт эмчилгээний зайлшгүй шаардлагатай байж болох хэдий ч нөгөөтээгүүр буруугаар ашиглавал донтох, хууль бус эргэлтэд орох өндөр эрсдэлтэй. Тиймээс

⁴⁶ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (1984). Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хяналтын удирдамж. Хандах: https://iris.who.int/bitstream/handle/10665/39299/9241541725_eng.pdf

Орос, Хятад, АНУ, Тайланд, Герман, Өмнөд Солонгос, Япон зэрэг улс орнууд эдгээр бодисын хэрэглээг хуулиар зохицуулж, олон давхар хяналтын тогтолцоог бий болгосон байдаг.

Оросын Холбооны Улсад мансууруулах бодисыг эмчилгээний зорилгоор хэрэглэх тохиолдолд эл харилцааг “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын тухай” хуулиар зохицуулдаг бөгөөд эмч нар зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий жороор эдгээр эмийг бичиж, эмийн сангууд зохих журмын дагуу бүртгэл хөтлөн олгодог. Жор бичихэд тусгай маягт ашигладаг бөгөөд төрөөс тавих хяналт маш өндөр. Тухайлбал, төрийн зүгээс хэрэглэсэн болон үлдэгдэл эмийн тоо ширхэг, хадгалалтын байдалд шалгалт хийдэг.

Харин Хятад улсад энэ төрлийн эмийг эмчилгээний зорилгоор хэрэглэхдээ улсын төвлөрсөн хяналтын системтэй уялдуулан зохицуулдаг. “Эмийн тухай хууль” болон “Мансуурлын эсрэг хууль”-аар энэ асуудлыг нарийвчлан зохицуулсан бөгөөд жор бичих эрх зөвхөн тодорхой шатны эмнэлгийн эмч нарт ногддог. Эмийн жагсаалтыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллага гаргаж, тусгай стандартын дагуу баталдаг бол хэрэглэсэн эмийг цахим системээр бүртгэж, тээвэрлэлт, хадгалалт, хэрэглэх хүртэл үе шат бүрд хяналт тавьдаг. Хятад улсын онцлог нь фентанил зэрэг эмчилгээний зорилгоор ашиглаж болохуйц синтетик мансууруулах бодист хатуу хяналт тогтоосон байдаг.

Америкийн Нэгдсэн Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таван ангилалд хувааж, эмчилгээний хэрэгцээ болон донтолт үүсгэх эрсдэлийн зэргээр нь ялгасан байдаг. Жишээлбэл, I ангилалд орсон бодисууд нь эмнэлэг эмчилгээний зориулалтгүй, аюултай тул хэрэглэхийг хориглодог. Харин II-V ангиллын бодисуудыг тухай улсын Хууль зүйн яамны харьяа Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх агентлаг (DEA)-д бүртгэлтэй эмч нар л бичиж, зохих зөвшөөрлийн дагуу хэрэглэдэг. Үүний зэрэгцээ, жор бичих, эм олгох, хяналт тавих бүх үйл явц DEA-ийн системээр бүртгэгдэж, донтолт үүсгэх, бусад хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлдэг байна.

Тайланд улсын хувьд олон жилийн турш хар тамхи, мансууруулах бодисын хууль бус хэрэглээтэй тэмцэж ирсэн туршлагатай. Эмчилгээний зорилгоор эдгээр бодисыг хэрэглэхэд “Мансууруулах бодисын тухай хууль”-д заасан ангиллын удирдлага болгодог. Тайландын хуулиар эдгээр эмийг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий эмч нар бичиж болох бөгөөд эмийн сангууд тухайн эмийг олгохдоо тодорхой бүртгэлийн дэвтэр, тайлангийн систем ашигладаг. Тайланд улс нь 2022 онд каннабисын төрлийн бодисыг гэмт хэрэгт тооцохгүй байхаар хуульчилсан анхны Азийн улс болсон хэдий ч 2024 онд тэрхүү төрлийн бодисыг дахин хууль бус ангилалд оруулж, зөвхөн эмчилгээний зориулалтаар хэрэглэж болох зохицуулалт руу буцсан.

Германд “Betäubungsmittelgesetz” буюу “Мансууруулах бодисын тухай хууль”-аар мансууруулах эмийг ангиллын дагуу I-III зэрэглэлд хуваадаг бөгөөд зөвхөн III ангиллын бодисыг эмчилгээний зориулалтаар жороор олгож болно. Эмч нар тусгай “BtM-Rezept” буюу мансууруулах бодисын жор бичих маягт ашигладаг бөгөөд энэхүү жорын дугаар, эм олгосон бүртгэл, хэрэглээ зэрэг нь бүгд BfArM буюу Холбооны Опиумын агентлаг⁴⁷ тайлагнадаг. Энэ нь Европын орнуудаас хамгийн өндөр хяналттай тогтолцоонд тооцогддог бөгөөд германы зохицуулалт нягт, институцийн төвшинд маш нарийн зохион байгуулагдсан байдаг.

БНСУ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих зохицуулалтад технологийн давуу талаа ашиглахыг оролдож цахим хяналтын систем нэвтрүүлсэн онцлогтой. “Мансууруулах бодисын тухай хууль”-аар зохицуулсан энэхүү системийг “NIMS” буюу Мансууруулах бодисын мэдээллийн удирдлагын систем гэж нэрлэдэг бөгөөд эмч, эмийн сан, эмнэлгүүдийг бүртгэж, цаг бүрээр хяналт тавьдаг. Энэхүү систем нь

⁴⁷ Хар тамхи, эм бэлдмэлийн холбооны хүрээлэн (BfArM) Хар тамхины холбооны агентлаг: Хангалтыг баталгаажуулах. Хандах: <https://www.bfarm.de/EN/Federal-Opium-Agency/node.html>

хэтрүүлэн жор бичих, давхар жор бичих зэргээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд үүний үр дүнд хуурамч хэрэглээ эрс багассан байна. Солонгосын туршлагаас цахим хяналт нь тухайн харилцааг зохицуулж буй хуулийг үр дүнтэй байлгах, хэрэгжилтийг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн байна.⁴⁸

Японд мансууруулах эмийг хэрэглэх зохицуулалт “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль”-д заасны дагуу тусгай зөвшөөрөл бүхий эмч, шүдний эмч, малын эмч нар бичиж болдог. Мөн Японд зөвхөн Засгийн газрын тусгай зөвшөөрлөөр эдгээр бодисыг улсын хилээр оруулах, гаргах бөгөөд тухайн үйл ажиллагааны журмыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Дээр дурдсан бүх орнууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн эмчилгээний зорилгоор, тодорхой нөхцөл, журамтайгаар хэрэглэдэг нийтлэг талтай.

3.4. Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс үүдэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ

Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнд өртсөн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ буюу албадан эмчилгээ, нөхөн сэргээх хөтөлбөр хэрэгжүүлэх тохиолдол их байдаг. Энэ нь гэмт этгээдийг нийгэмд дахин нэгтгэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой хар тамхи, мансууруулах бодисын эсрэг тэмцэх бодлого юм.

АНУ-д, “drug court” буюу мансууруулах бодистой холбоотой зөрчил, хэрэг хянан шийдвэрлэх тусгай шүүхүүд ажилладаг⁴⁹ бөгөөд анх удаа хэрэглэсэн эсвэл бага хэмжээний хэрэглээнд холбогдсон этгээдийг албадан эмчилгээнд хамруулж, шүүхийн хяналт дор нөхөн сэргээх хөтөлбөрт оролцуулдаг.⁵⁰

ОХУ-д Эрүүгийн хууль болон Захиргааны зөрчлийн тухай хуульд зааснаар сэтгэцийн эмгэггүй боловч хэрэглээний хамааралтай этгээдүүдэд эрүүгийн шийтгэлийн оронд шүүхийн шийдвэрээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж,⁵¹ наркологийн диспансерт бүртгэж, эмчилгээ хийлгэх үүрэг хүлээлгэдэг.⁵²

БНХАУ-д Мансууруулах бодистой тэмцэх тухай хуулийн 38-р зүйлийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ болох “compulsory detoxification center” ажилладаг. Хэрэглэгчийг 1–2 жил хүртэл хугацаанд тусгай байгууллагад саатуулах замаар эмчилгээ, сэтгэл заслын эмчилгээ, хөдөлмөрийн сургалт зэрэг багц арга хэмжээг хэрэгжүүлдэг. Гэсэн хэдий ч энэ арга хэмжээ нь хүний эрхийн зөрчиж буй хэмээн шүүмжлэлд өртөх нь бий.⁵³

БНСУ-д “rehabilitation disposition” хэмээх шүүхийн шийдвэрээр 6–12 сарын хугацаанд албадан нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах эрүүгийн хуулийн зохицуулалттай байдаг.

⁴⁸ Kim, SY., Cho, NW., Yoo, MS. et al. (2023). Narcotics information management system in South Korea: system development and innovation. BMC Health Serv Res 23, 73. Хандах: <https://doi.org/10.1186/s12913-023-09060-z>

⁴⁹ Deschenes & Greenwood (1994). Maricopa County's drug court: An innovative program for first-time drug offenders on probation. Journal of Drug Issues, 24(1), 136–147. Хандах: <https://doi.org/10.1080/23277556.1994.10871195>

⁵⁰ Blick, D. (2022). Addressing the Drug Problem: The Establishment of Drug Courts and Evaluating their Effectiveness (Master's thesis). Rochester Institute of Technology. Хандах: <https://repository.rit.edu/cgi/viewcontent.cgi?article=12658&context=theses>

⁵¹ ОХУ-ын Эрүүгийн хууль, 72 дугаар зүйл

⁵² Мөн тэнд.

⁵³ Yang, J., & Giummarra, M. J. (2021). Compulsory and voluntary drug treatment models in China: A need for improved evidence-based policy and practice to reduce the loaded burden of substance use disorders. International Journal of Drug Policy, 92, 103063. Хандах: <https://doi.org/10.1016/j.drugpo.2020.103063>

Хэрвээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээд эмчилгээнд сайн дураар хамрагдвал эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжтой.

Тайланд улсын мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэх тогтолцоог албан бусаар 3 төрлийн системд хуваан тодорхойлдог. Үүнд: сайн дурын эмчилгээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, ял шийтгэлийн суурьтай арга хэмжээнүүд орно⁵⁴. Тайланд улс сүүлийн жилүүдэд хатуу ял шийтгэлээс илүүтэй “*Treat First, Jail Later*” гэх бодлогыг нэвтрүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ял шийтгэл оноохын өмнө хэрэгжүүлдэг болсон.

ХБНГУ-д “*Therapy instead of punishment*” (*Therapie statt Strafe*) буюу “Шийтгэлийн оронд эмчилгээ” хэмээх бодлого хэрэгждэг. Энэ нь шүүхээс ял оноохын оронд сэтгэцийн болон мансууруулах бодисын хамааралтай этгээдийг эмчилгээний төвд албадан эмчлүүлэх шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалт юм.⁵⁵ Энэхүү шийдвэр нь тухайн хэргийг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж чанараас хамаарна. Германы Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (*Strafprozessordnung, StPO*)-ийн §153а зүйл-ийн дагуу, тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд прокурор эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох боломжтой. Тус хуулийн зохицуулалт нь яллагдагч мансууруулах бодисын хэрэглээ эсвэл хамааралтай холбоотой эмчилгээ, нөхөн сэргээх хөтөлбөрт хамрагдахаар зөвшөөрсөн тохиолдолд прокурорын зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох боломжийг олгодог.⁵⁶

⁵⁴ Pearshouse, R. (2009). Compulsory drug treatment in Thailand: Observations on the Narcotic Addict Rehabilitation Act B.E. 2545 (2002). Canadian HIV/AIDS Legal Network. Хандах: https://sagecollection.ca/wp-content/uploads/2014/08/cdt_thailand-eng.pdf

⁵⁵ Boellinger, L. (2002). Therapy instead of punishment for drug users – Germany as a model? European Addiction Research. Хандах: <https://doi.org/10.1159/000049679>

⁵⁶ SE Legal. Drug offences and narcotics criminal law in Germany. Хандах: <https://se-legal.de/criminal-defense-lawyer/drug-offences-and-narcotics-criminal-law-in-germany/?lang=en>

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэхүү судалгаагаар Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Тайландын Хаант Улс, Япон Улсын хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг зохицуулж буй суурь хуулиуд болон тэдгээрийн хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллагуудыг авч үзсэн бөгөөд судалгаанд авч үзсэн орнуудын нийтлэг тал нь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисын эрх зүйг тусгай бие даасан хууль болон эрүүгийн хуулиар зохицуулж байна.

Уг харилцааг зохицуулж буй хуулиудын хувьд, АНУ, БНСУ, Тайланд зэрэг улсууд хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис гэсэн ойлголтуудыг тодорхой ангилан, эдгээрт багтах бодисууд (опиум, каннабис, марихуана, поппи гэх мэт)-ыг тус бүрийн онцлогт нийцүүлэн ялгавартайгаар хуульчилж, хууль бус эргэлттэй холбоотой зөрчил, гэмт хэрэгт оноох ял шийтгэлийн хэмжээг ангилал тус бүрээр тодорхойлсон. ОХУ-ын эрх зүйн зохицуулалт нь тухайн хэрэгт холбогдсон бодисын төрлөөс гадна бодит хэмжээнд тулгуурлан эрүүгийн хариуцлагын хүрээ, ял шийтгэлийг тогтоодог онцлогтой. Япон Улсын хувьд, тухайн улсын нутаг дэвсгэрт түгээмэл хэрэглэгддэг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис бүрийг онцлог шинж чанар, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хүрээг харгалзан тус бүрд нь зориулсан бие даасан хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, Каннабисийн тухай хууль, Опиумын тухай хууль, Сэргээгч бодисын хяналтын тухай хууль, мөн Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хяналтын тухай хууль зэрэг нь тухайн төрлийн бодисын ангилал, ашиглалтын нөхцөл, хариуцлагын хэлбэрийг тусгайлан тодорхойлсон бөгөөд энэ нь эрх зүйн зохицуулалтыг илүү нарийн, үр нөлөөтэй болгож, хэрэгжилтийг оновчтой хангахад чиглэгдсэн цогц тогтолцоог бүрдүүлжээ.

Харин Монгол Улсын хувьд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг ангилан ялгалгүй ерөнхийд нь томьёолсон нь нэг төрлийн ял шийтгэл оноох үндэслэл болж байна. Гэтэл шинжлэх ухааны үндэслэлээр авч үзвэл мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисууд нь хүний бие махбод, сэтгэцэд үзүүлэх нөлөө, донтолтын шинж, хэрэглээний эрсдэл, эрүүл мэндэд үзүүлэх хор уршгийн хувьд эрс ялгаатай. Иймд гадаад орны туршлагаас харвал, эдгээр ялгаатай байдлыг эрх зүйн түвшинд тусгаж, хууль зүйн ангилал, ял шийтгэлийн шатлалд тусган боловсруулах нь зүйтэй болох нь харагдаж байна.

Уг харилцаанд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хувьд, судалгаанд хамрагдсан улс орнуудын туршлагаас үзэхэд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомжууд нь төрийн байгууллагуудад хяналт тавих, хязгаарлалт тогтоох, зөвшөөрөл олгох эрх, чиг үүргийг тодорхой зааж өгсөн байдаг. Эдгээр эрх бүхий байгууллагууд нь тухайн улсын аюулгүй байдал, эрүүл мэнд, хил хяналтын бодлоготой уялдан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийтлэг байдлаар гаалийн байгууллага, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн яам, цагдаагийн байгууллагууд, мөн зарим тохиолдолд тусгай мөрдөн шалгах болон тагнуулын байгууллагууд хамтарч ажиллаж буй нь ажиглагддаг. Ийнхүү салбар дундын уялдаа холбоотой, чиг үүргийн давхар хяналт бүхий байгууллагын зохион байгуулалт нь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй үр дүнтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Мөн НҮБ-аас баталсан олон улсын конвенцуудад нийцүүлэн, дээрх судалгаанд хамрагдсан гадаад улс орнууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг зөвхөн анагаах ухаан болон шинжлэх ухааны судалгааны зорилгоор хүлээн зөвшөөрч, энэхүү хэрэглээг хууль ёсны хүрээнд зохицуулсан эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн байна. Энэ хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий эмч нарын бичсэн жороор эмчилгээний зориулалтаар ашиглах, мөн

батлагдсан судалгааны хөтөлбөр, төсөлд зориулан хязгаарлагдмал хэмжээгээр ашиглах нөхцөл, журмыг хуулиар нарийвчлан тогтоосон нь олон улсын эрх зүйн зарчимтай нийцэж буйг харуулж байна. Ийнхүү хууль ёсны хэрэглээг тодорхой хэм хэмжээнд хязгаарлан зөвшөөрөх нь бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн салбарт зайлшгүй шаардлагатай эм, эмийн бодисын хүртээмжийг хангах тэнцвэртэй хандлагын нэг хэлбэр болж байна.

Эрүүгийн болон захиргааны хариуцлагын зохицуулалтын хувьд судалгаанд хамрагдсан улс орнуудын хооронд бодлогын чиг хандлага харилцан адилгүй байгааг онцлон дүгнэж болно. Тухайлбал, Хятад, Тайланд, БНСУ зэрэг улсууд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой үйлдлийг маш хүнд гэмт хэрэгт тооцож, өндөр хэмжээний ял шийтгэл (үүнд цаазаар авах ял ч багтдаг)-ийг оноодог хатуу бодлого баримталж байна.

Харин Герман, АНУ зэрэг орнуудын хувьд тухайн бодисын хэрэглээнд хүргэсэн нөхцөл байдал, хувь хүний нөхөн сэргээх боломж, эмчилгээний шаардлагыг харгалзан үздэг илүү зөөлөн, урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх чиглэлийн бодлого хэрэгжүүлж байна. Жишээлбэл, албадан эмчилгээ, нөхөн сэргээх төвд хамруулах, хяналтын доорх нөхцөлд эмчилгээ хийх зэргээр нийгэмшүүлэх арга хэмжээг чухалчилж буй нь тухайн улсын нийгмийн хандлага, эрх зүйн философийн ялгааг илэрхийлж байна.

Эдгээр туршлагаас харахад, хариуцлагын хэлбэр, ял шийтгэлийн бодлого нь тухайн улсын хууль тогтоомж төдийгүй соёл, нийгмийн үнэт зүйл, бодлогын зорилгоос хамааран өөр өөрөөр хэрэгждэг байна.

НОМ ЗҮЙ

Koçoğlu, S. (2024). A review of the Russian Federation's main legal regulations on drug abuse and their impact on prevention. Хандах: https://www.addicta.com.tr/Content/files/sayilar/21/AOP-ADDCT_20240222_nlm_new_indd.pdf

Embassy of the People's Republic of China in the United States. (2023, July 6). Хандах: http://us.china-embassy.gov.cn/eng/zggs/202307/t20230706_11108971.htm

Ч.Нямсүрэн. (2022). Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, Хандах: https://www.uih.mn/upload/sudalgaa/files/208_7447220.pdf

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (1984). Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хяналтын удирдамж. Хандах: https://iris.who.int/bitstream/handle/10665/39299/9241541725_eng.pdf

Deschenes & Greenwood (1994). Maricopa County's drug court: An innovative program for first-time drug offenders on probation. *Journal of Drug Issues*, 24(1), 136–147. Хандах: <https://doi.org/10.1080/23277556.1994.10871195>

Blick, D. (2022). Addressing the Drug Problem: The Establishment of Drug Courts and Evaluating their Effectiveness (Master's thesis). Rochester Institute of Technology. Хандах: <https://repository.rit.edu/cgi/viewcontent.cgi?article=12658&context=theses>